

Хавсралт 4

СУДАЛГААНЫ ТӨСӨЛ ЗАРЛАХ, СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ

Үе шат 1 – Судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийг зарлах

8-р сар Судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийг Оюу Толгой, Рио Тинто Монгол ХХК, ШУТИС-ийн нийгмийн сүлжээгээр зарлана.

Үе шат 2 – Өргөдөл авах эцсийн хугацаа

9 сар Судалгааны баг нь дэвшүүлэх төслийн саналаа тухайн оны 9 дүгээр сарын 30-ны дотор мэдүүлнэ.

Үе шат 3 – Нарийн бичгийн дарга өргөдлийг хүлээн авч тодруулах зүйлсийг авна.

10 сарын эхээр Өргөдлийн сүүлчийн хугацаанаас хойш, нарийн бичгийн дарга өргөдлүүдийг хянаж, хэрвээ шаардлагатай бол өргөдөл мэдүүлэгчдээс тодруулга авна.

Үе шат 4 – Үнэлгээний комисс судалгааны төслийн саналыг шалгаруулах, ашиг сонирхлын зөрчилгүй эсэхээ мэдэгдэх

10 сарын дундуур Комиссын гишүүд судалгааны тэтгэлэг хүссэн саналуудын жагсаалтыг үзэж, аль саналд нь үнэлгээ хийх боломжтой болохоо мөн аль саналыг ашиг сонирхлын улмаас үнэлэхээс татгалзах зэргээ мэдэгдэнэ. Гишүүд мэдэгдлээ хийсний дараа уг жагсаалтыг комиссын хамтарсан даргад өгнө.

Үе шат 5 – Комиссын даргын үүрэг

10 сарын сүүлээр Комиссын хамтарсан дарга комиссын гишүүдийн тохирох чиглэл, аль саналуудыг үнэлэх боломжтойгоо илэрхийлсэн байдал болон татгалзасныг харгалзан үзэж Үнэлгээний Комиссын гишүүдийн дунд ирсэн саналуудыг хувааж өгнө. Санал бүрийг хоёр гишүүн үнэлэх бөгөөд нэгдүгээр болон хоёрдугаар үнэлээчээр томилогдоно.

Үе шат 6 – Үнэлэх үйл явц

11 сарын эхээр Нэгдүгээр үнэлээчийг өөрийн үнэлгээ дүгнэлтийг өгөхийг урина. Өөрсөдтэйгөө ямар нэг байдлаар холбоотой, жишээ нь өөрсдийн болон хамт ажиллагчийн боловсруулсан төсөл, өөрөөс нь зөвлөгөө авч байсан хүмүүсийн төслийн саналыг үнэлэх ёсгүй.

11 сарын дундуур

Хоёрдугаар үнэлээчийг өөрийн үнэлгээ дүгнэлтийг өгөхийг урина. Хоёрдугаар үнэлээч нь төслийн саналыг үнэлэхдээ өөрийн мэргэшсэн чиглэлийн түвшинг дараах 3 түвшингээр мэдэгдэнэ: 1) эксперт, 2) тухайн сэдвийн талаар тодорхой ойлголттой, 3) тухайн сэдвийн талаар ойлголтгүй. Магадлан хянах механизмыг шударга байлгах үүднээс, хөндлөнгийн үнэлээчид ‘сэдвийн талаар ойлголтгүй’ гэж мэдэгдсэн үнэлээчээр тухайн төслийн саналыг үнэлүүлэхгүй. Санал бүрийг хоёрдугаар үнэлээчээр үнэлүүлнэ.

Үе шат 7 – Нарийн бичгийн даргын цааш үргэлжлүүлэх ажил

11 сарын сүүлээр

Нарийн бичгийн дарга бүх үнэлгээний тайланг хүлээн авч, холбогдох мэдээллүүдийг нэгтгэн Комиссын хэлэлцүүлэгт бэлтгэнэ.

Үе шат 8 – Комиссын хурлаар төслийн санал бүрийг авч хэлэлцэх

12 сарын эхээр

Комиссын хурлыг Оюу толгой компаний байранд хуралдуулж, үнэлгээний тайлан бүрийг нэг бүрчлэн хэлэлцэж, санхүүжилт олгох эсэх талаар шийдвэр гаргана.

Комиссын дарга Төслийн Удирдах Хороонд судалгааны санхүүжилт олгох төслүүдийг санал болгоно. Төслийн удирдах хороо уг саналыг хэлэлцэж, батлана.

12 сарын дундуур

Судалгааны тэтгэлэгт шалгарсан төслүүдийг их сургуулийн болон Оюу толгой компанийн вэб сайтаар дамжуулан зарлана.

Комиссын гишүүдийн төслийн саналд өгсөн санал зөвлөмжийг үнэлгээний комиссын гишүүний нэрийг дурдалгүйгээр судлаачдад өгч, төслийн саналыг сайжруулах зөвлөмжийг өгнө.